

Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт

2011,02,01

Булган аймаг

Боловсрол соёл, шинжилэх ухааны сайдтай байгуулсан гэрээг хэрэгжүүлж: 2010 оны гэрээгээр 2 нэрийн 21 бүтээгдэхүүн нийлүүлэхээр харилцан тохиролцож хэрэгжилтийг тооцвол гэрээний биелэлт 98,0 хувьтай дүгнэгдлээ.

Иргэд, багш, суралцагчдад зориулсан 11264 ширхэг ном бүхий “Англи номын сан”-г Булган суманд байгууллаа. ЕБС-иудын 60.0 хувь интернэтэд холбогдоод байна.

БСШУЯ-наас 2010 онд 12 сургуульд 148 компьютер олгож, сүүлийн 2 жилд нийт 250 компьютерээр хангалаа.

БНСУ-ын “Шим тэжээл” ТББ-ын хөрөнгө оруулалтаар Дашинчилэн сумын сургууль “Үдийн хоол” загвар цайны газартай боллоо.

МСҮТ нь 100 ортой дотуур байр ашиглалтанд хүлээн авлаа. Хөдөө аж ахуйн мэргэжилтэн бэлтгэх МСҮТ 2010 онд шинээр байгуулагдлаа.

Газар хөдлөлийн станцын шинэ барилгын зураг төсвийг хийлгэж, 2011 онд 195,0 сая төгрөгийн барилга угсралтын хийхээр боллоо.

Тэшиг суманд шинээр соёлын төв барьж, Баян-Агт сумын соёлын төвийн барилга угсралтын ажлыг 2011 онд эхлүүлж, Орхон, Баяннуур, Могод, Бүрэгхангай сумдууд Соёлын төвийн сандлаа шинэчилж, бүх Соёлын төвийг компьютер, принтертэй болгож 13,0 сая төгрөг зарцууллаа.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдтай байгуулсан гэрээг хэрэгжүүлж: 2010 оны гэрээгээр 5 нэрийн 36 бүтээгдэхүүн нийлүүлэхээр харилцан тохиролцож хэрэгжилтийг тооцвол гэрээний биелэлт 90,0 хувьтай дүгнэгдлээ.

2010 онд байнгын 617, улирлын 787, нийт 1404 ажлын байрыг бий болгож, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг Хутаг-Өндөр, Гурванбулаг, Могод, Сэлэнгэ сумдад хэрэгжүүлж 30 малчин өрхийг хамрууллаа.

Өрхийн хөгжлийг дэмжих аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, 2009 онд 303 өрх, 2010 оны 374 өрх, нийт 677 өрхийн амьжиргааг дээшлүүлж, орон гэргүй 164 өрхөд гэр, 54 орон сууцны байшин олголоо.

Амьжиргааг нь дээшлүүлэх өрхөөс сонгон “Хүнс тэжээлийн дэд хөтөлбөр”-т хамруулж, 365 өрхөд 45,1 сая төгрөгийг зарцууллаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аймгийн чуулганыг хийж, зохион байгуулалтын асуудал, тайлан хэлэлцэн, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар сургалт хийлээ.

Хөдөлмөрийн бага чуулганыг ҮЭХ, АОЭХ-той хамтран зохион байгуулж, нийгмийн 3 талт гэрээг дүгнэлээ.

Эрүүл мэндийн сайдтай байгуулсан гэрээг хэрэгжүүлж: 2010 оны гэрээгээр 9 нэрийн 30 бүтээгдэхүүн нийлүүлэхээр харилцан тохиролцож хэрэгжилтийг тооцвол гэрээний биелэлт 92.0 хувьтай дүгнэгдлээ.

Эхийн эндэгдэлгүй ажиллаж, нийт халдварт өвчнийг 284 тохиолдлоор буурууллаа. 0-1 насны хүүхдийн эндэгдлийг 2009 оны түвшинд барьж, урьдчилан сэргийлэх болон амбулторын үзлэг, ор хоногийн ашиглалтыг нэмэгдүүллээ.

“Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” -ийн ажлыг зохион байгуулж эрүүл мэндийг дэмжигч сум, байгууллагын тоог нэмэгдүүлэн “Эрүүл мэндийн салбарын хөгжлийн дунд хугацааны хөтөлбөрийг /2010-2015 он/-ийг батлуулан хэрэгжүүлж эхэллээ.

Хишиг-Өндөр суманд Хүн эмнэлгийн 20 ортой шинэ барилга баригдаж, сайдын багцаас Баян-Агт сумын Хүн эмнэлгийн барилгад 30,0 сая, Дашинчилэн сумын хүн эмнэлгийн барилгад 40,0 сая, Хутаг-Өндөр сумын хүн эмнэлгийн барилгад 38,4 сая төгрөгийн их засварын ажил хийгдлээ.

Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдтай байгуулсан гэрээг хэрэгжүүлж: Бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээгээр 5 нэр төрлийн бүтээгдэхүүний ангид багтах 19 бүтээгдэхүүн 42 зорилтыг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулж 92,0 хувиар биелүүллээ.

Мал сүрэг 2.3 сая толгой тоологдож улсын хэмжээнд малын тоогоор 5-р байранд орлоо.

Аймгийн хэмжээнд малтай өрх 9689, малчин өрх 7459 нэг малчин өрхөд ногдох малын тоо 307 толгой болж, 1000 дээш малтай өрх 261 байна.

Үр тариа 36.1 мянган тн хураахаар төлөвлөж 36.4 мянган тн буюу нэгжээс 12.3цн, төмс 7.8 мян.тн төлөвлөж 8.2 мян.тн буюу нэгжээс 97.4, хүнсний ногоо 3.0 мян.тн төлөвлөж 3.2 мян.тн буюу 97.7 цн хураан авлаа. Байгалийн хадлан бэлтгэлийг 87.0 мянган тн бэлтгэхээр төлөвлөж 101281 тн хадлан бэлтгэлээ.

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэлээр хангах зорилт дэвшүүлж төмсний хэрэглээг 100 хувь, гурилын хэрэгцээг 2 дахин их, хүнсний ногоо 65.0 хувь, махны хэрэгцээг 5 дахин их, сүүний хэрэгцээг 100.0 хувь дотоодын үйлдвэрлэлээр бэлтгэлээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай байгуулсан гэрээг хэрэгжүүлж:

Байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтын гэрээгээр 4 бүтээгдэхүүн нийлүүлэх үүрэг хүлээж, 97,5 хувь биелүүлж ажиллалаа.

Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, 310 га-д ойжуулалт хийснээс 230 га-г тарьцаар ойжуулж, 80 га-д байгалийн сэргэн ургалтанд туслах ажлыг хийж, 78-86 хувийн амьдралттайгаар улсын комисс хүлээж авсан.

5 сумын нутагт 10 булаг шандны эхийг хашиж хамгаалах ажлыг сонгон шалгаруулалтанд ялалт байгуулсан “Байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн холбоо” төрийн бус байгууллагаар гүйцэтгүүллээ.

Зам, тээвэр, барилга, хот байгууллын сайдтай байгуулсан гэрээг хэрэгжүүлж:

Аймгийн Засаг бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээгээр нийт 21 бүтээгдэхүүн нийлүүлэх үүрэг хүлээснээс аймгаас шалтгаалах ажлууд бүрэн хийгдэж, гэрээний биелэлт 95.2 хувь байна.

Салбарын хэмжээнд 16 ажил бүрэн хэрэгжиж, 3 ажил 80-90 хувьтай, 2 ажил 70-80 хувьтай байна.

Газрын батлагдсан төсөв 85.6 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 85.05 сая төгрөгийн санхүүжилт олгогдож, 85.6 сая төгрөг зарцуулж, 557.9 мянган төгрөгийн хэмнэлт /хэтрэлт/-тэй ажилласан байна.

Батлан хамгаалахын сайдтай байгуулсан гэрээг хэрэгжүүлж:

Бүтээгдэхүүн нийтлүүлэлт санхүүжилтийн гэрээгээр нийт 4 бүтээгдэхүүний 19 зорилтыг хэрэгжүүлж 2,7 сая төгрөгийн санхүүжилт авч 94,0 хувиар хэрэгжүүлж ажиллалаа.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд 3 сарын 16-18-ний өдрүүдэд “Марш тактик”-ийн тэмцээн зохион байгуулж хэвшлээ. Энэ үеэр дунд сургуулийн сурагчдын дунд соёл, спортын олон төрөлт тэмцээн зохион байгуулж, 2-р 11 жилийн сургуулийн сурагчдын “Жаран хар”-ын тоглолтыг зохион байгууллаа.


Батлан хамгаалах сайдын өгсөн үүрэг чиглэлийн дагуу 2010 оны 5 сарын 23-25-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд “Батлан хамгаалах бодлого зорилт ЗХ-ний үйл ажиллагааг сурталчилах өдөрлөг”-ийг зохион байгууллаа. Мөн ээлжит 1, 2-р цэрэг татлагыг зохион байгуулж Батлан хамгаалахын сайдын өгсөн хяналтын тоог 100 хувь биелүүллээ.

Хууль зүй дотоод хэргийн сайдтай байгуулсан гэрээг хэрэгжүүлж:

Бүтээгдэхүүн нийлүүлэлт санхүүжилтийн гэрээгээр 648,7 сая төгрөгийн санхүүжилт авч 4 ангийн бүтээгдэхүүн нийлүүлэв.

Гэмт хэрэгтэй тэмцэх шуурхай байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр автопаркыг шинэчлэх ажлыг хийж эргүүлийн автомашиныг нэгээр нэмэгдүүлж, шуурхай албаны автомашиныг шинэчиллээ. Аймгийн хэмжээнд 7-10 сарын хооронд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг их гарсан тул энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сарын аян зарлаж, удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөр хэлэлцэн үүрэг өгөв.

10000 хүнд ногдох гэмт хэргийн тоог улсын болон аймгийн дундажтай харьцуулахад:



Хууль зүйн сайдтай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт санхүүжилтийн гэрээний биелэлт 90,5 хувьтай байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР